



МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон яамны шагнал олгох журам"-ыг 1 дүгээр, "Хүндэт тэмдгийн загвар"-ыг 2 дугаар, яамны "Жуух бичгийн загвар"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Түвшинтөр/-т даалгасугай.

САЙД



С.ЧУЛУУН

Соёлын сайдын 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн А/ОС дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ХҮНДЭТ ТЭМДЭГ
БОЛОН ЯАМНЫ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ** СТС2233 6594204

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан журам, жагсаалтын дагуу төрийн албан хаагч болон шаардлага хангасан зарим иргэнийг “Ардын авьяастан” хүндэт тэмдэг, “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон яамны шагналаар шагнаж, урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Яамны шагнал нь яамны “Жуух бичиг” байна.

1.3. Шагналыг яамны, Засгийн газрын шагнал гэсэн дарааллаар олгох бөгөөд өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил ажиллаж байгаа бол дараагийн шатны шагналыг олгох зарчим баримтална.

Хоёр. Шагнал олгох болзол

2.1. Соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, ажлын өндөр амжилт гаргасан, онцгой бүтээл туурвил бүтээсэн, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, соёл, урлагийн салбарт 12-оос, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан тэргүүний шилдэг хүмүүсийг “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр, 5-аас доошгүй жил ажилласан тэргүүний хүмүүсийг яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнаж болно.

2.2. Дараахь тохиолдолд энэ журмын 2.1-д заасан ажилласан жилийн хугацааг харгалзахгүйгээр Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнаж болно:

2.2.1. олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож эхний гурван байрт шалгарсан, олны таашаалд нийцсэн онцгой содон уран бүтээл бүтээн туурвисан;

2.2.2. мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийч, үлээвэр хөгжимчнөөр ажиллаж энэ журмын 2.1-д заасан хугацааны 50 хувийг хангасан;

2.2.3. 1990 оноос өмнө Улсын тэргүүний уран сайханч шагнал хүртсэн, улс, олон улсын их наадмын алт, мөнгө, хүрэл медаль хүртэж байсан.

2.3. “Ардын авьяастан” тэмдгээр ардын урлагийн тодорхой төрлөөр мэргэшиж, уран бүтээлээ сурталчилж олны хүртээл болгосон, соёлын биет бус өвийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжлийн бус уран бүтээлч, соёлын өвийг өвлөн уламжлагч, ардын авьяастныг шагнаж болно.

2.4. Монгол Улсын Соёлын сайд санаачлан хэн нэг албан тушаалтан, иргэнийг салбарын шагналаар шагнахаар нэр дэвшүүлбэл яамны Төрийн захиргааны удирдлагын газар хариуцаж тухайн хүнийг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1. Соёл, урлагийн салбарт 10-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шагналд нэр дэвшүүлж болох бөгөөд энэ журмын 3.3-т заасан хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө дараахь баримтыг бүрдүүлэн харьяалах аймаг, нийслэлийн соёл, урлагийн газраар дамжуулан цаасан болон цахим хэлбэрээр ирүүлнэ:

- 3.1.1. энэхүү журмын хавсралтаар баталсан анкет;
- 3.1.2. байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл;
- 3.1.3. ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт;
- 3.1.4. урьд шагнагдсан бол энэ тухай тэмдэглэл;
- 3.1.5. журмын 2.2-т заасан болон бусад онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, нотолгооны хуулбар;
- 3.1.6. шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан бичиг.

3.2. Төрийн өмчит соёл, урлагийн байгууллагууд энэ журмын 3.1-д заасан баримтаа соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дамжуулан ирүүлнэ.

3.3. Шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.5-д заасан Үндэсний их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, тухайн байгууллагын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тэгш ой, Соёл, урлагийн ажилтны өдөр, Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан олгоно.

3.4. Энэ журмын 3.1-д заасан баримтыг дутуу бүрдүүлсэн бол тодорхойлолтыг буцаана.

Дөрөв. Шагналыг шийдвэрлэх

4.1. Яамны шагналын асуудал хариуцсан албан хаагч энэ журмын шаардлагад нийцсэн баримтыг шагналын асуудал хариуцсан зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

4.2. Зөвлөлийн дарга нь Төрийн захиргааны удирдлагын газрын дарга байх ба бүрэлдэхүүнд Соёл, гэгээрлийн газрын дарга, Урлаг, уран бүтээлийн газрын дарга, Соёлын өвийн газрын дарга байна. Зөвлөлийн нарийн бичгийн даргаар шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллана.

4.3. Шагналын зөвлөлийн олонхийн санал авсан иргэнд сайдын шийдвэрээр шагналыг олгож, мэдээллийг яамны цахим хуудаст байршуулан, шагналыг аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл тодорхойлсон байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

Тав. Тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

5.1. Шагналын тэмдэг, үнэмлэх, жуух бичгийг өөрийн буруу биш шалтгаанаар үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн хүний ажиллаж байгаа, эсхүл ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагын албан тодорхойлолт, өөрийнх нь өргөдлийг үндэслэн, үнийг нь төлүүлж нэг удаа солих буюу нөхөн олгож болно.

5.2. Яам энэ журамд заасан шагналаар шагнуулсан, шагналын тэмдэг, үнэмлэхээ нөхөн болон сольж авсан албан хаагч, иргэдийн мэдээллийн сантай байна.

Салбарын тэргүүний ажилтан
хүндэт тэмдэг болон яамны
шагнал олгох журмын хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Овог:
2. Нэр:
3. Регистрийн дугаар:
4. Нас:
5. Хүйс:
6. Яс үндэс:
7. Бүртгэлтэй хаяг:
8. Ажлын газрын үндсэн захиргаа:
9. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/



№	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			
4			
5			

10. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он, сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			
3			
4			
5			

11. Нийт ажилласан жил:
12. Үүнээс тухайн салбарт ажилласан жил:
13. Шагнагдаж байсан шагналууд /он цагийн дараалал баримтлан бичих бөгөөд Яамны бусад шагналаар шагнагдсан бол түүний хуулбарыг заавал хавсаргана./

№	Шагналын нэр	Шагнал, үнэмлэхийн дугаар	Шагнагдсан он
1			
2			
3			
4			
5			

14. Шагнуулах үндэслэл: /Товч, тодорхой бичнэ/

.....
.....
.....
.....
.....

15. Шагнуулахад онцгойлон харгалзаж үзэх амжилт:

.....
.....
.....
.....
.....

16. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

17. Хамт олны саналын хувь:

18. Шагналыг хүлээн авах /байгууллагын/ хариуцсан ажилтны нэр, утасны дугаар, мэйл хаяг:

.....
.....


.....
дарга /захирал, эрхлэгч/

.....
гарын үсэг, тамга
тэмдэг

/...../
гарын үсгийн тайлал

---oo0oo---

Соёлын сайдын 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 1/05 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР

1. “Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”-ийн загвар:

Металл хийцтэй /гагнуур тогтохуйц зэс, төмөр/, дүрслэл нь бүхэлдээ Монгол хүмүүний ариун цагаан авьяас билгээр дэлхийн болон үндэсний соёл урлаг баяжин хөгжиж, мандан бадарч байхын бэлгэдлийг агуулсан байна.

Тэмдэг нь ромбо хэлбэртэй, эргэн тойрон шар, цагаан хүрээтэй, тэмдгийн дээд хэсэгт улаан дэвсгэр дээр соёмботой, дунд хэсэгт “**Соёлын тэргүүний ажилтан**” гэж Кирилл үсгээр бичсэн, доод хэсэгт дэлгэмэл ном дээр хөгжмийн дүрсийг дүрсэлсэн, тэмдгийн доод хэсгийг цэнхэр өнгөөр давхар эмжсэн 2-3 мм хүрээ гаргасан байна.

Урт нь 45 мм, өргөн нь 25 мм, зузаан нь 2 мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар металл гадаргуу дээр СТА-... гээд тэмдгийн дугаарыг бичсэн байна.

Тэмдгийг дагалдуулан үнэмлэх олгох бөгөөд үнэмлэхийн дугаар нь “1” гэсэн индексийн араас хэвтээ зураас татаад тухайн тэмдгийг олгосон он, ташуу зураас татаад олгож байгаа тэмдгийн дугаарыг бичсэн байна. Жишээ нь 1-2020/123

2. “Ардын авьяастан хүндэт тэмдэг”-ийн загвар:


Металл хийцтэй /гагнуур тогтохуйц зэс, төмөр/, дүрслэл нь бүхэлдээ ардын урлагийн бүх төрөл наран цацрах мэт мандан бадрах бэлгэдэлтэй. Тэмдэг нь хоёр хэсгээс бүрдэнэ. Үндсэн хэсэг нь дугуй хэлбэртэй, алтан шар өнгөтэй, нарны цацрагийг бэлгэдсэн товгор найман талт том цацраг хээ тус бүрийн хооронд дөрвөн ширхэг жижиг цацраг бүхий хүрээтэй, тэмдгийн голд 25 мм голчтой, 3 мм-ийн давхар хүрээ бүхий дэвсгэрийг голлуулан ухаж, морин хуурчийн дүрсийг гарган, дээл, малгай, хуурын толгойг хөх өнгөөр дүрсэлж, давхар хүрээний доод хэсэгт “**Ардын авьяастан**” гэж Кирилл үсгээр, хөх өнгөөр бичнэ.

Үндсэн хэсгийн диаметр нь 35 мм, зузаан нь 2 мм байна. Зүүлт бүхий хоёр тэгш өнцгийн үндсэн хэсэгтэй холбогдох сэнжний хэсэг нь доош мохоо өнцөг үүсгэсэн гоёмсог хэлбэртэй байх ба алтан шар өнгийн хүрээтэй, улаан өнгөтэй дэвсгэрийн доод хэсэгт мандан бадрахын бэлгэдэл галын дөлийг дүрсэлсэн байна.

Тэмдгийн зүүлт хэсгийг үндсэн хэсэгтэй гогцоо цагаригаар холбож, ар талд тогтоогч зүүтэй, үндсэн хэсгийн арын гялгар металл гадаргуу дээр ТАА-.... гээд тэмдгийн дугаарыг бичсэн байна.

Тэмдгийг дагалдуулан үнэмлэх олгох бөгөөд үнэмлэхийн дугаар нь “2” гэсэн индексийн араас хэвтээ зураас татаад тухайн тэмдгийг олгосон он, ташуу зураас татаад олгож байгаа тэмдгийн дугаарыг бичсэн байна. Жишээ нь 2-2020/23

Соёлын сайдын 2020 оны 9 дүгээр сарын 14. -ний өдрийн А/25. дугаар тушаалын 3 дугаар хавсралт



СОЁЛЫН ЯАМНЫ ЖУУХ БИЧГИЙН ЗАГВАР

Жуух бичиг нь 297х210 мм хэмжээтэй хуудсыг А5 хэмжээгээр хоёр нүүрт хуваан, тус бүрийг 10 мм өргөн түмэн насан хээгээр хүрээлсэн байна. Хүрээний дотор хэсгийг нийтэд Монгол үндэсний бэлгэдэлт хээгээр дэвсгэрлэн чимэглэсэн байна. Эхний нүүрэнд дээд хүрээнээс доош 20 мм зайд 60х30 мм хэмжээтэй соёмбо, соёмбоос доош 50 мм зайд голлуулан **“Дугаар ...”** гэж бичсэн байна.

Үндсэн бичвэр нь: Хоёр дахь нүүрэнд хүрээнээс доош 30 мм зайд нүүрийг голлуулан **“Эрхэм хүндэт Танаа”** гэсэн үгийг голлуулан бичнэ.

Түүний доор 15 мм зайд **“Соёлын салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг Тань өндрөөр үнэлж, Монгол Улсын Соёлын яамны “ЖУУХ БИЧИГ”-ээр шагнав.”** гэж бичсэн байна.

Уг өгүүлбэрээс доош 30 мм зайд **Монгол Улсын Соёлын сайд** гээд сайдын овог, нэрийг голлуулан бичсэн байна.

Хоёр дахь нүүрийн доод хэсэгт **20.... оны ... сарын ны өдөр Улаанбаатар хот** гэсэн бичвэрийг голлуулан бичнэ.

Бүх бичвэрийг хөх цэнхэр өнгөтэй, бичмэл хэвээр бичсэн байна.

Жуух бичгийн дугаарлахдаа “3” гэсэн индексийн араас хэвтээ зураас татаад тухайн жуух бичгийг олгосон он, ташуу зураас татаад олгож байгаа жуух бичгийн дугаарыг давхцуулахгүйгээр бичсэн байна. Жишээ нь 3-2020/45

---oo0oo---